



## ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2017 оны 02 дугаар сарын 08-ны өдөр

Тендер шалгаруулалтын нэр: Монголбанкинд 250 хэрэглэгчийн эрхтэй Microsoft Office 365 Business програм хангамж нийлүүлэх

Тендер шалгаруулалтын дугаар: МО-2017/02

Монголбанк нь эрх бүхий тендерт оролцогчоос 250 хэрэглэгчийн эрхтэй Microsoft Office 365 Business програм хангамж нийлүүлэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн бичиг баримтыг бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдлээр нь 50,000.00 (тавин мянга) төгрөгөөр худалдан авч болно. Тендерийн баримт бичгийн үнийг Монголбанкны 4101000014 тоот дансанд (дансны нэр: тендерийн хороо) тушаана. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

Борлуулалтын хэмжээ: **2014, 2015, 2016 онуудын борлуулалтын орлогын арифметик дундаж нь 50 сая төгрөгөөс багагүй байна,**

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: Тендерт санал болгож байгаа үнийн дүнгээс багагүй байна.,

Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жил: Сүүлийн 3 жил буюу 2014, 2015 онуудын жилийн эцсийн аудитаар баталгаажсан санхүүгийн тайлан, 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан

Тендерийн хамт 1 сая төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Гадаадын этгээд тендерт оролцох эрхгүй бөгөөд тендерт оролцогчид давуу эрхийн зөрүү тооцохгүй болно.

Хувилбарт тендер ирүүлэхийг зөвшөөрөхгүй.

Тендерийг 2017 оны 03 сарын 10-ны өдрийн 10 цаг 00 минутаас өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2017 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 10 цаг 30 минутад нээнэ.

Сонирхсон этгээд тендерийн бичиг баримт болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

## МОНГОЛБАНК

Бага тойруу-3, 15160, Улаанбаатар хот,  
Монголбанкны “Өргөтгөл” байрны 2 давхар, 37 тоот өрөө,  
Утас: (976-11) 311039, Факс: (976-11) 311471